

Өмнөх

Дараах



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Барилгын ерөнхий зүйл

Архитекторуудын ёс зүйн хэм хэмжээ

Ерөнхий зарчим

MNS 5543 : 2005

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Улаанбаатар хот
2005 он

1 2 3 4 5 6 7



ӨМНӨХ ҮГ

ISO буюу Олон Улсын Стандартчиллын Байгууллага (ОУСБ) нь үндэсний стандартчиллын байгууллагуудын (ОУСБ – ын гишүүн) дэлхий дахины холбоо юм. Олон улсын стандарт боловсруулах ажлыг ОУСБ нь техникийн хороогоор дамжуулан гүйцэтгэдэг. Гишүүн байгууллага бүхэн техникийн хорооны субъект болохыг сонирхдог бөгөөд техникийн хорооноос зөвшөөрөл өгөх эрхийг энэхүү хороо төлөөлөн гүйцэтгэнэ.

Олон Улсын Стандартын төслийг батлахын тулд ОУСБ – ын төлөөлөгч тэрхүү Олон улсын стандартыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө тус техникийн хорооноос түүний танилцуулгыг гишүүн байгууллагуудад тарааж дэмжлэг авдаг.

Энэхүү стандартыг анх 1996 оны 7-р сард Испани Улсын Барселон хотод хуралдсан Олон Улсын Архитекторуудын Холбооноос дэмжиж гаргасан болно. Монгол улс ОУАХ-ны жинхэнэ гишүүн бөгөөд 2004 оны 02-р сарын 06-ны өдрийн Монголын Архитекторуудын Эвлэлийн Зөвлөгөөнөөс үндэсний стандарт болгох шийдвэр гаргасны дагуу энэхүү стандартыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн тогтоолоор батлуулсан болно. Уг стандартыг Монгол Улсын стандартчиллын тогтолцооны суурь стандарт MNS 1.2:2000, MNS 1.3: 2000-ын дагуу СХҮТ-ийн барилгын стандартын шинжээч Т. Энхтуул хянав.

Энэхүү стандартыг ТХ22/Барилга, замын стандартчиллын техникийн хороо хэлэлцэн зөвшилцөж, Үндэсний Зөвлөлийн хуралдааны тогтоолоор баталсан болно.

Энэ стандартын анхны үзлэгийг 2011 онд, дараа нь 5 жил тутамд хийнэ.

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв (СХҮТ)

Энх тайвны өргөн чөлөө 46А,

Улаанбаатар 211051, ш/х –48

Утас: 263860, 266754, факс: 976-11-458032

E – mail: masm@mongol.net

©СХҮТ, 2005

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэж, олшруулах эрх нь гагцхүү СХҮТ (Стандартчиллын төв байгууллага) – д байна.

Ангилалтын код: 91.010.10

Архитекторуудын ёс зүйн хэм хэмжээ. Ерөнхий зарчим	MNS 5543 : 2005
Standards of professionalism in Architectural practice. General principle.	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2005 оны 12- сарын 08-ны өдрийн 58 дугаар тоот тогтоолоор баталсан.

Энэхүү стандарт нь 2006 оны 01-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандарт нь зөвлөмжийн стандарт болно.

1. Зорилго

Энэ стандартын зорилго нь Олон улсын архитекторуудын холбоо (ОУАХ)-ноос баталж гаргасан Архитекторуудын ёс зүйн олон улсын зөвлөмжийн стандартыг Монгол улсад мөрдүүлэхэд оршино.

2. Хамрах хүрээ

Энэ стандартыг архитектурын шинжлэх ухаан ба архитекторын боловсролын салбарт ажилладаг буюу хот байгуулалт, барилгын зураг төсөл зохиох, зөвлөх үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг бүх архитектор мэргэжлийн хүмүүс дагаж мөрдөхөд хамаарна.

3. Норматив ишлэл

-ОУАХ-ны Архитекторуудын ёс зүйн олон улсын зөвлөмжийн стандарт
-Олон улсын зөвлөмжийн стандартыг үндэсний стандарт болгох тухай Монголын Архитекторуудын Эвлэлийн 2004 оны 1 дүгээр улирлын ээлжит зөвлөгөөний шийдвэр.

4. Ерөнхий шаардлага ба зарчим

4.1. Архитекторын мэргэжлийн төлөөлөгчид хөдөлбөргүй зарчимч, мэдлэгтэй байх, мэргэжлийн өндөр стандартыг ариунаар сахиж, түүгээрээ нийгэмд мэргэжлийн онцгой мэдлэг чадварын хувь нэмрийг оруулж, архитектурын хүрээлэл, түүний соёлын хөгжилд голлох байр эзэлнэ.

4.2. Архитекторууд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх үедээ баримтлах зарчим, биеэ авч явах хэм хэмжээг энэхүү стандартаар тодорхойлов.

4.3. Архитектор мэргэжил нь нийгэмд үйлчилж, нийгмийг баяжуулж байдгийн хувьд нийгмийн өмнө хүлээх хариуцлага, захиалагчдын өмнө болон архитектурын бүтээгдэхүүнийг хэрэглэх хэрэглэгчид буюу үйлчлүүлэгчдийн өмнө хүлээх хариуцлага, архитектурын шинжлэх ухаан ба урлагийн өмнө буюу мэргэжлийн өмнө хүлээх хариуцлага, мөн түүнчлэн архитектурын хүрээллийг цогцлуулахад тусалдаг барилгын үйлдвэрлэлийн төлөөлөгчид буюу мэргэжил нэгт нөхдийн өмнө хүлээх хариуцлагыг тус тус тодорхойлов.

5. Архитекторуудын баримтлах зарчим

Архитекторууд нь олон улсын түвшинд хэрэглэгдэх дараах нийтлэг бөгөөд үндсэн зарчмуудыг мөрдөнө. Үүнд:

1 дүгээр зарчим

5.1. Нийтлэг үүрэг

Архитекторууд нь дараах нийтлэг үүрэгтэй байна.

5.1.1. Архитекторын боловсрол эзэмших, сургалтанд хамрагдах, дадлага хийх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах явцдаа хуримтлуулсан онолын болон дадлага туршлагын системтэй мэдлэгтэй байх;

5.1.2. Архитекторын боловсрол эзэмшүүлэх, сургах, мэдлэгийг шалгах үйл ажиллагааг зохион байгуулахдаа, мэргэжлийн үйлчилгээ хийх үүрэг хүлээсэн архитектор нь энэ үүргийг биелүүлж чадах мэргэжлийн стандартын шаардлагыг хангахуйцаар бэлтгэгдсэн гэдэг итгэл үнэмшлийг нийгэмд бүрэн өгч чадахаар зохион байгуулах;

5.1.3. Архитекторын мэдлэг мэргэжлийг бататган хөгжүүлж, архитектурын бүхий л ололтыг хүндэтгэн, түүнд хувь нэмрээ оруулж байхын зэрэгцээ архитектурын урлаг ба шинжлэх ухаанд зүтгэх үйлстээ мэдлэгт тулгуурласан, мэргэжлийн санаа бодлыг эн тэргүүнд тавьж байх;

5.1.4. Өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд мэдлэг чадвараа тасралтгүй дээшлүүлэхийг эрмэлзэх;

5.1.5. Архитекторын боловсрол, сургалт, дадлага, судалгаа шинжилгээний үйл ажиллагаандаа гоо зүйн стандартыг байнга дээшлүүлэхийг эрмэлзэх;

5.1.6. Архитектуртай уялдаа шүтэлцээтэй бусад урлагийг хөгжүүлэх болон барилгын салбарын хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах;

5.1.7. Өөрийн үйл ажиллагааны дотоод эмх цэгц, үр ашигтай байдлыг хангаж, үйл ажиллагаандаа хяналт болон дүн шинжилгээ хийж ажиллах ба үр бүтээлтэй ажиллахад шаардагдах тооны мэргэшсэн ажиллагсадтай байх;

5.1.8. Хэрэв архитектор шууд удирдлаган дороо өөрийн өгсөн үүрэг даалгавраар хэн нэгэн ажилтан буюу өөр этгээдийг ажиллуулж байгаа бол түүний мэдлэг чадварыг дэмжиж баталгаажуулах, шаардлагын хэрээр түүний ажлыг хангалттай хяналтын дор явуулах;

5.1.9. Архитекторуудтай харьцаж буй нийгмийн төлөөлөл нь худал хуурмаг, луйвар, санаатайгаар залилан мэхлэгдэхээс хамгаалагдах ёстой.

2 дугаар зарчим

5.2. Нийгмийн өмнө хүлээх үүрэг

Архитекторууд нийгмийн өмнө дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

MNS 5543 : 2005

5.2.1. Мэргэжлийн үйл ажиллагаандаа мөрдөгдөх хууль тогтоомж, норм дүрэм, стандартыг чандлан биелүүлж, өөрийн үйл ажиллагааны нийгэм болон экологид үзүүлэх эерэг ба сөрөг үр дагаврыг сайтар тооцоолсон байх;

5.2.2. Архитектурын бүтээл туурвиж буй орчныхоо үнэт зүйлсийн тогтолцоо, байгалийн болон соёлын өвийг хүндэтгэж, түүнийг хамгаалан хадгалахад хувь нэмрээ оруулах үүрэгтэй. Хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, амьдрах орчны чанар, нөхцөлийг сайжруулахыг байнга эрмэлзэх үүрэгтэй бөгөөд өөрийн үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг идэвхтэй болон идэвхгүй ашиглагч хүн бүрийн ашиг сонирхолд өөрийн үйл ажиллагааны үр дагаврыг хэрхэн нөлөөлөхийг бүрэн хэмжээгээр тооцоолсон байх;

5.2.3. Өөрийгөө болон өөрийн үйл ажиллагаагаа танилцуулах буюу сурталчлахдаа худал хэлэх, төөрөгдөлд оруулах, хуурах арга хэлбэрээр илэрхийлэхээс татгалзах;

5.2.4. Архитекторын үйл ажиллагааны хэлбэр нь түүний үйл ажиллагааг өөр төрлийн үйл ажиллагаатай хольж хутгах, сольж андуурахааргүй байх;

5.2.5. Өөрийн үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг чанд биелүүлэх;

5.2.6. Үйл ажиллагаа явуулж байгаа улс, байгууллагынхаа ёс зүйн болон сахилга батын дүрмийг (хэрэв энэ дүрэм нь олон улсын болон архитекторын төрөлх орны хууль дүрмийг зөрчөөгүй бол) мөрдөж ажиллах;

5.2.7. Нийгмийн аливаа үйл ажиллагаанд иргэний болон мэргэжилтний эрхийн дагуу оролцож болох бөгөөд архитектурын асуудлаар нийгмийг мэдээлэлжүүлэхэд хувь нэмэр оруулах үүрэгтэй.

3 дугаар зарчим

5.2. Үйлчлүүлэгчдийн өмнө хүлээх үүрэг

Архитекторууд нь үйлчлүүлэгчдийн өмнө дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.3.1. Өөрийн мэргэжлийн үйл ажиллагааг хичээнгүй, чин сэтгэлээсээ, мэдлэгтэй, мэргэшсэн байдлаар гүйцэтгэж, мэргэжлийн бүх үйлчилгээний хүрээнд шаардагдах техникийн болон мэргэжлийн стандартуудыг тооцоолсон, урьдаас таамаглаагүй, шударга үзэл бодлыг илэрхийлэх;

5.3.2. Үйлчлүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд санхүүгийн болон техникийн хангалттай эх үүсвэр, нөөцтэй байх үед л мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэх;

5.3.3. Мэргэжлийн ажлаа хийхдээ хичээнгүй, анхааралтай хийх;

5.3.4. Захиалгат ажлыг гүйцэтгэхдээ шалтгаангүйгээр хугацаа хожимдуулахгүй байх, өөрийн боломж, чадлын хэмжээг зөв тооцоолж, тохиролцсон хугацаанд хийж өгөх;

5.3.5. Өөрийн үйлчлүүлэгчдэд захиалгат ажлын явц, чанар, үнэ, төлбөр тооцоонд хамааралтай бүх асуудлуудын талаар тодорхой мэдээллийг өгч байх;

MNS 5543 : 2005

5.3.6. Эзэмшсэн боловсрол, сургалт, дадлагын үр дүнд тухайн захиалгат ажилд холбогдолтой, мэдлэгийн тодорхой хүрээнд шаардагдах мэргэшил олж авсан нөхцөлд л өөрийн үйлчлүүлэгчдэд бие даасан зөвлөгөө өгөх хариуцлага үүрэх;

5.3.7. Гэрээ хийгч хоёр тал дараах нөхцлүүдээр, бичгээр тодорхой зөвшилцөлд хүрч чадаагүй бол архитекторууд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

Үүнд:

- Ажлын цар хүрээ
- Харилцан хүлээх хариуцлагын хуваарилалт
- Хариуцлагын аливаа хязгаарлалт
- Шагнал ба түүнийг тооцох арга
- Хэлцлийг хүчингүй болгох нөхцөл;

5.3.8. Үйлчлүүлэгчдэд хамаарах нууцыг хадгалах үүрэгтэй ба үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр буюу бусад хууль ёсны байгууллагын зөвшөөрөлгүйгээр (тухайлбал шүүхийн шийдвэрээр шаардагдаагүй бол) нууцад хамаарах мэдээллийг задруулах эрхгүй;

5.3.9. Үйлчлүүлэгч, эзэмшигч ба гүйцэтгэгчдийн ашиг сонирхолд харшилж болзошгүй мэт санагдах, өөрт мэдэгдэж буй нөхцөл байдлын тухай тэдгээрт мэдэгдэж байх үүрэгтэй бөгөөд энэхүү нөхцөл байдал нь дээрх хүмүүсийн хууль ёсны ашиг сонирхолд харшлаагүй тухай итгэл үнэмшлийг олж авч, гэрээт үүргээ биелүүлэх архитекторын үүргийг гүйцэтгэхэд саад болохгүй гэдгийг мэдэж авсан байх ёстой.

4 дүгээр зарчим

5.3. Мэргэжлийн өмнө хүлээх үүрэг

Архитекторууд нь мэргэжлийнхээ өмнө дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.4.1. Мэргэжлийн эрхэм зорилго ба итгэл үнэмшлийн гуйвшгүй байдлаа хамгаалах бөгөөд ямар ч тохиолдолд бусдын хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хүндэтгэн үздэг байх;

5.4.2. Өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа шударга үнэнчээр явуулах;

5.4.3. Архитекторуудын албан ёсны байгууллагын гишүүнээс хөөгдсөн буюу архитекторуудын ямар нэг бүртгэлээс өөрийн хүсэлтээр бус хасагдсан хүнийг өөрийн хамтран ажиллагчаар сонгохгүй байх;

5.4.4. Өөрийн бүхий л үйл ажиллагаагаараа архитектурын мэргэжлийн эрхэм зорилгыг ханган биелүүлэхийг чармайх ба өөрийн ажилтан, төлөөлөгчдөөс энэхүү стандартын дагуу биеэ авч явахыг шаардаж, өөрсдийн үйлчлүүлэгчдийн өмнө хэн нь ч итгэл алдахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

5 дугаар зарчим

5.5. Мэргэжил нэгт нөхдийн өмнө хүлээх үүрэг

Архитекторууд нь мэргэжил нэгт нөхдийнхөө өмнө дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
MNS 5543 : 2005

5.5.1. Өөрийн эрхийг хүндэтгэн мэргэжил нэгт нөхдийнхөө мэргэжлийн тэмүүлэл, оруулсан хувь нэмрийг болон өөрийн хөдөлмөр, бүтээлд бусдын оруулсан хувь нэмрийг хүлээн зөвшөөрөх ёстой.

5.5.2. Арьс өнгө, шашин шүтлэг, тахир дутуу байдал, гэр бүлийн болон хүйсийн байдлаар ялгаварлан гадуурхах үзлээс ангид байх;

5.5.3. Бусад архитекторын уран бүтээлийн санааг, зохиогчийн зөвшөөрөлгүйгээр авч ашиглахгүй байх;

5.5.4. Аливаа тендер, захиалга олж авах буюу ажилд томилогдох зорилгоор бэлэг сэлт болон өөр ямар нэгэн байдлаар авилга өгөхгүй байх;

5.5.5. Бие даасан зөвлөхийн үйлчилгээ үзүүлж байхдаа, өөрөөс нь асуугаагүй байхад шагналын хэмжээг урьдчилан хэлэхгүй байх, үйлчилгээний төлбөр тооцооны хэмжээг хэлэхийн өмнө ажлын хэмжээ, хүндрэлийг бүрэн тодорхойлох мэдээлэл авч тооцооны дараа хэлэх;

5.5.6. Бие даасан зөвлөх үйлчилгээ үзүүлж байхдаа өөр архитекторын уг үйлчилгээг үзүүлэхэд санал болгосон үнийг өөрчлөхгүй байх талаар анхаарах;

5.5.7. Өөр архитекторын эзэлж байгаа албан тушаалыг шударга бусаар авах оролдлого хийхгүй байх;

5.5.8. ОУАХ буюу түүний гишүүн салбаруудын хүлээн авч болохгүй гэж зарласан архитектурын уран бүтээлийн уралдаанд оролцохгүй байх;

5.5.9. Ямар нэгэн уран бүтээлийн уралдааны шүүгчдийн бүрэлдэхүүнд сонгогдсон бол уралдаанд тавигдаж буй ажлуудад аливаа байдлаар оролцохгүй байх;

5.5.10. Бусад архитекторыг хорон санаагаар буюу шударга бусаар шүүмжлэх, гүтгэх, нэр төрийг нь гутаах, эсвэл түүний ажлыг үгүйсгэх оролдлого хийхгүй байх;

5.5.11. Өөрт нь санал болгосон зураг төсөл буюу мэргэжлийн үйлчилгээг өөрийн мэдэж байгаагаар буюу сурвалжилж мэдсэнээр тухайн захиалагч өөр архитекторт санал болгож байсан бол энэ тухай тэр архитекторт заавал мэдэгдэх;

5.5.12. Бусад архитекторын ажлын тухай санал бодлоо хэлэх үйл ажиллагаанд татагдан оролцсон бол (болох гэж байгаа буюу болж байгаа шүүх үйл ажиллагаанд хор учруулахааргүй бол) энэ тухайгаа тэр архитекторт мэдэгдэх;

5.5.13. Хоршин ажиллагчид болон ажилтнуудаа ажлын тохиромжтой нөхцлөөр ханган, ажлынх нь хөлсийг шударгаар олгож, тэдний мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх;

5.5.14. Архитекторууд мэргэжлийн нэр хүндээ ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааныхаа ололт амжилтаар бүрдүүлэх бөгөөд бусдын гүйцэтгэсэн мэргэжлийн ажлыг үнэлж, зохих шан хөлсийг өгдөг байх үүрэгтэй.

ТӨГСӨВ.